



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 38 (323)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хураамжийн хэмжээг тогтоох тухай*
- *Шингэрүүлсэн шатдаг хийг хэрэглээнд нэвтрүүлэх талаар авах арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны аравдугаар сарын 15

№ 38 (323)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

532.	Хураамжийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 205	861
533.	Тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 206	863
534.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 207	863
535.	Шингэрүүлсэн шатдаг хийг хэрэглээнд нэвтрүүлдэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 208	870
536.	Дүрэм, бүрэлдэхүүн батлах тухай	Дугаар 209	870

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

Хураамжийн хэмжээг тогтоох тухай

Газрын тухай хуулийн 36.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хугацааг сунгуулахад төлөх хураамжийн хэмжээг хавсралт ёсоор тогтоосугай.

Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох, гэрчилгээг бусдад шилжүүлэх, гэрчилгээний

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Хууль зүй, дотоод хэргийн сайд

Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2003 оны 205 дугаар тогтоолын хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, БУСАД ШИЛЖҮҮЛЭХ, ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУГАЦААГ СУНГАХАД ТӨЛӨХ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг шинээр олгоход төлөх хураамжийн хэмжээ:

Үйлчилгээний төрөл	Ангилал	Хураамжийн хэмжээ (төг)	
		Иргэн	Аж ахуйн нэгж, байгууллага
Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох	Нийслэл	10000	35000
	Аймгийн төвийн сум	5000	10000
	Бусад сумд	3000	5000
Газар ашиглах эрхийн гэрчилгээ олгох	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн Нэгж	35000	
	Гадаадын иргэн, Харьяалалгүй хүн	10000	

Тайлбар: Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үргэгдүүлсэн тохиолдолд түүнийг нөхөн олгоход дээрх хураамжийн хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлж авна.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэхэд төлөх хураамжийн хэмжээ:

Үйлчилгээний төрөл	Ангилал	Хураамжийн хэмжээ (төг)	
		Иргэн	Аж ахуйн нэгж, байгууллага
Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх	Нийслэл	10000	35000
	Аймгийн төвийн сум	5000	10000
	Бусад сумд	3000	5000

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгахад төлөх хураамжийн хэмжээ:

Үйлчилгээний төрөл	Хураамжийн хэмжээ (төг)	
	Иргэн	Аж ахуйн нэгж, байгууллага
Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах	3000	6000
Газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгах	Гадаадын иргэн, харьяалаггүй хүн	Гадаадын хөрөнгө оруулагттай аж ахуйн нэгж
	5000	10000

4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрын архивын лавлагаа, зурган мэдээллээр үйлчлэхэд авах хураамжийн хэмжээ:

Үйлчилгээний төрөл	Ангилал	Хураамжийн хэмжээ (төг)
Газрын архивын лавлагаа, зурган мэдээллээр үйлчлэх	Архивын лавлагаа	200
	өгөх (1 хуудас)	Баталгаажилтын схем
	Зурган мэдээллээр үйлчлэх (нэгж талбар бүр)	1000
		2500



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтад дор дурдсан агуулгатай 46 дахь заалт нэмсүгэй.

1. "Засгийн газрын комисс, Үндэсний

46	Зүүн хойд Азийн орнуудын хамтын ажиллагааг бүс нутгийн хөгжлийн шинэ нөхцөл, шаардлагад нийцүүлэн идэвхжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх Засгийн газрын ажлын хэсэг	Санхүү, эдийн засгийн сайд
----	--	----------------------------

2. "Түмэн бүс" хөтөлбөрийн гишүүн орны жилгийн хандивт зарцуулах 25.0 мянган ам. долларыг 2004 оны улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг

Санхүү, эдийн засгийн сайд Ч. Улаанд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Санхүү, эдийн засгийн сайд

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг хянан жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, гадаад зах зээлийг өргөжүүлэх, энэ чиглэлээр олон улсын гэрээ байгуулах боломжийг судалж, холбогдох арга хэмжээ авахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун нарт тус тус үүрэг болгосугай.

1. "Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг 1 дүгээр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, хөтөлбөрийг

Үйлдвэр, худалдааны сайд

Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2003 оны 207 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

нь гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, 46.8 хувь нь хамтарсан, 14.9 хувь нь дотоодын үйлдвэр байна.

1.1. Нийгэм, эдийн засагт эзлэх байр суурь

Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарт 2002 оны байдлаар 100 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 38.3 хувь

Дээрх үйлдвэрүүдэд 20 орчим мянган хүн ажиллаж байгаа нь аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын 12.0 хувийг эзлэж байна.



Тус салбар аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 5.3 хувийг үйлдвэрлэж байгаа бөгөөд нийт экспортод оёмол бүтээгдэхүүн 16.2 хувийг эзлэж байна.

1.2. Зах зээлийн эрэлт хэрэгцээ, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар

Оёдлын үйлдвэрүүд нь хөгжиж байгаа орнуудын жишгээр АНУ, Европын холбооноос манай улсад олгосон худалдааны нэн тааламжтай нөхцөлийг ашиглан гадаадын захиалагчийн материалаар бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлож байна. Дотоодын үйлдвэрүүд нь дийлэнхдээ гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан үйлдвэрүүдийн туслан гүйцэтгэгчээр ажиллаж байна.

Бүтээгдэхүүний өртгийн 65-90 хувийг эзэлдэг үндсэн, туслах материал импортоос бүрэн хараат, тээврийн болон үйлдвэрлэлийн зардал өндөр зэргээс шалтгаалан оёмол бүтээгдэхүүн нь үнийн хувьд дотоодын зах зээл дээр өрсөлдөх чадваргүй байна.

Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын бизнес эрхлэх орчин ялгаатай байгаа нь өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хүндрэл учруулж байгаа юм.

1.3. Техник, технологийн түвшин

Манай улсад 1995 оноос 2.0 мянга гаруй ердийн болон тусгай зориулалтын оёдлын машин, 700 гаруй автомат, индүү, пресс, 9.0 мянга гаруй туслах төхөөрөмж, 2.0 мянга гаруй бэлтгэх, эсгэх машин гадаадын хөрөнгө оруулалтаар орж ирсэн нь үйлдвэрлэлд шинэ дэвшилтэт технологи нэвтрэхэд бодитой хувь нэмэр оруулсан юм. Гэвч бүтээгдэхүүний загвар зохион бүтээлт, технологийн баримт бичгийн боловсруулалт шаардлага хангахгүй байна.

1.4. Ажиллах хүч

Ажиллагсдын хөдөлмөрийн бүтээмж хөгжиж байгаа орноос 1.5-2 дахин доогуур, шилжилт хөдөлгөөн их, тогтвор суурьшил бага, ажлын цагийн

ашиглалт сул байна. Манай улсад 1986 оноос оёдлын үйлдвэрийн инженер, техникийн ажилтныг дотооддоо бэлтгэж байгаа боловч мэргэжлийн ажилтан бэлтгэх тогтолцоо үгүйлэгдэж байна. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын менежментийн тогтолцоо зах зээлийн шаардлага хангахгүй байна.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

2.1. Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн давуу тал

Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь:
-үйлдвэрлэлийн бэлтгэл ажиллагаа багатай, бүтээгдэхүүн үйлдвэрлэх мөчлөг богино, хөрөнгө оруулалт бага шаарддаг;

-хөрөнгө оруулалтын эргэн төлөх хугацаа богино;

-үйлдвэрлэлийн чиглэл, бүтээгдэхүүний нэр төрлийг богино хугацаанд хялбар өөрчлөх боломжтой;

-хүрээлэн байгаа орчинд үзүүлэх дарамт бага, экологийн хувьд цэвэр үйлдвэрлэлийн тоонд багтдаг.

Манай орны хувьд:

-олон улсын зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэх худалдааны таатай нөхцөлд хамрагдсан;

-АНУ болон Европын зах зээлд өөрийн байр суурийг олсон;

-дэвшилтэт техник, технологи үйлдвэрлэлд нэвтэрсэн зэрэг давуу талтай байна.

2.2. Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өмнө тулгарч байгаа бэрхшээл

Монгол Улс 2004 оноос АНУ-тай Зүүн өмнөд Азийн орнуудтай ижил худалдааны нөхцөлөөр харилцана. Үүнтэй уялдан манай улсад үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнд төлөх

үйлчилгээний үнэ, гадаадын хөрөнгө оруулалт буурах, дотоодын зах зээлийн импортоос хамаарах хамаарал өсөх, ажилгүйдэл нэмэгдэх, "нийгмийн эмзэг бүлэг"-ийн өрхийн амьжиргааны түвшин буурах зэрэг эдийн засаг, нийгмийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх хүндрэлүүд гарч болзошгүй байна.

Иймд Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортын хэмжээг тогтвортой хадгалах, дотоодын бүтээгдэхүүнээр хүн амын хэрэгцээг хангах бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ:

- шинэ зах зээл нээж олох, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад харилцааг хөгжүүлж, худалдааны тааламжтай нөхцөл бүрдүүлэх;

- үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчин бий болгох;

- импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих;

- салбарын менежментийг сайжруулж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэн бүтээмжийн өсөлтийг хангах.

3.3. Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд баримтлах чиглэл

Хөтөлбөрийг хэрэгжүүлж, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дараахь чиглэлийг баримтална:

- гадаадын шинэ зах зээлд гарах бүх талын боломжийг судалж, хэрэгжүүлэх;

- бизнесийн орчинг Зүүн болон Зүүн өмнөд Азийн орнуудын жишигт хүргэх арга хэмжээ авах;

- гадаадын захиалагчийн үйлдвэрлэлийг дэмжих, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын бизнес эрхлэх ялгаатай байдлыг арилгах татварын орчин бүрдүүлэх;

- төсвийн байгууллагын захиалгыг дотоодын үйлдвэрлэлд чиглүүлж, зах зээлийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- өмнө нь ажиллаж байсан орон нутгийн жижиг, дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагааг сэргээж, дотоодын бүтээгдэхүүнээр хүн амын хэрэгцээг хангах нөхцөл бүрдүүлэх;

- бизнес эрхлэгчдийн хоршин ажиллах ажиллагааг гүнзгийрүүлэх, менежментийг боловсронгуй болгох, бизнес эрхлэх дэвшилтэт аргыг эзэмшүүлэх, мэргэжлийн ажилтан бэлтгэх сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулан ажиллуулах замаар боловсон хүчнийг чадваржуулж, үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийн өсөлтийг хангах таатай орчин бий болгох;

- бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэн тасралтгүй сайжруулах, бага оврын шинэ дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, үйлдвэрлэлийн уян хатан байх чадварыг дээшлүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн зарчим нь төрийн байгууллага болон салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус бусад байгууллага, үйлдвэр, аж ахуйн газар, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоонд тулгуурлах явдал юм.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ банк, санхүү, татвар, гаалийн тогтолцоо, худалдаа,



хангамж, тээврийн системийг боловсронгуй болгох асуудлыг иж бүрнээр авч үзнэ.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын "Экспортын үйлдвэрлэлийг дэмжих", "Ноолуур", "Ноос", "Арьс шир", "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих" "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөр" зэрэг хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй уялдуулна.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2003-2005 он. Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, суурилагдсан хүч чадлын ашиглалтыг дээшлүүлэн, үйлдвэрлэлийг хэвийн өсөлттэй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хоёрдугаар үе шат: 2005-2008 он. Гадаад зах зээлд салбарын эзлэх байр суурийг бататгаж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Гуравдугаар үе шат: 2009-2015 он. Оёмол үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг Зүүн өмнөд Азийн орнуудын түвшинд хүргэнэ.

Зургаа. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ нь 1-2 дугаар үе шатны зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. 3 дугаар үе шатны зорилтыг тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тогтооно.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт жил бүр тусган холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авах замаар хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2. Хөтөлбөрт заасан зорилт, арга хэмжээг холбогдох яам, байгууллага хариуцан хэрэгжүүлж, тэдгээрийн явц, харилцан уялдаа, үр дүнд Үйлдвэр, худалдааны яам хяналт тавина.

3. Үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь хөтөлбөрийн хэрэгжилт, явцын үр дүнг холбогдох байгууллагуудаас авч хөгжтэн үе шат бүрийн төгсгөлд Засгийн газарт тайлагнана.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Үйлдвэр, худалдааны сайд нь холбогдох байгууллагын төлөөлөгчдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

Найм. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дор дурдсан санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

а/улсын төсөв;

б/олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж;

в/гадаадын хөрөнгө оруулалт;

г/үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;

д/бусад

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

1. Бүтээгдэхүүний экспорт тогтвортой нэмэгдэж, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дэлхийн зах зээлд эзлэх байр суурь өснө.

2. Ажлын байр нэмэгдэж, ажилгүйдэл буурна.

3. Орон нутагт үйлдвэрлэл хөгжих таатай орчин бүрдэнэ.

4. Салбарын үйл ажиллагааны импортоос хамаарах хамаарал буурна.

Засгийн газрын 2003 оны 207 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ОЁМОН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛ

№	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Шөврдөгдөх хөрөнгө сая Төгрөг	Хариуцан хэргэжүүлэх байгууллага
1.	Шинэ зах зээл нээж олох, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад харилцааг хөгжүүлж, худалдааны тааламжтай нөхцөл бүрдүүлэх	<p>1/ Шинэ зах зээл нээж илрүүлэх, түүнд нэвтрэх, худалдааны таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлээр олон улсын байгууллага, гадаад орнуудтай гэрээ байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх</p> <p>2/ Хөрш болон зүүн өмнөд Азийн орнуудтай хамтран ажиллаж, Монголд үйлдвэрлэсэн оёмол бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг авах</p> <p>3/ Гадаад орнуудаас манай бүтээгдэхүүнд ногдуулдаг гаалийн татварыг бууруулах боломжийг судалж, хэргэжүүлэх талаар тухайн орнуудтай хамтран ажиллах</p> <p>4/ UNIDO, JETRO зэрэг үйлдвэр, худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмждэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцан мэдээлэл солилцох, хөдөлмөрийн нөхцөл, бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчний чадварийг дээшлүүлэх сургалт явуулах</p> <p>5/ Монголд хөрөнгө оруулагчдыг дэмжих Олон улсын чуулга уулзалтаар "Oiemol, сүлжмэл бүтээгдэхүүн ба Made in Mongolia" тусгай булан нээж ажиллуулах, сурталчилгааг өргөжүүлэх</p> <p>6/ "Magic Show" /АНУ/, "Inter Stuff" /ХБНГУ/, "Pret-a-Porte" /Франц/ зэрэг олон улсын төрөлжсөн үзэсгэлэн, яармалт монголын үйлдвэрлэгчид оролцох, үйл ажиллагаагаа сурталчилгахад нь дэмжлэг үзүүлэх</p>	<p>2003-2008</p> <p>2004-2008</p> <p>2004-2008</p> <p>2003-2008</p> <p>2004-2008</p> <p>2004-2008</p>	<p>10.0</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>6.0</p> <p>18.0</p>	<p>УХЯ, ГХЯ</p> <p>УХЯ, ГХЯ</p> <p>УХЯ, ГХЯ, СЗЭЯ</p> <p>УХЯ, ГХХОГ</p> <p>ГХХОГ, МХАУТ, МОБУХ</p> <p>ГХХОГ, МХАУТ</p>

	7/ Монголын өөмөл бүтээгдэхүүний гадаад, шинэ зах зээлийн талаар мэдээлэл, судалгаа гаргаж үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг хангах, бизнес эрхлэгчдийн хооронд холбоо харилцаа тогтооход дэмжлэг үзүүлэх	2003-2008	1.5	ГХЯ
2.	Үйлдвэрлэл, нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчин бий болгох 1/ Өөмөл бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эд, материалын гаалийн татварын төлөлт, зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж боловсруулах 2/ Экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг үйл ажиллагаа нь тогтворжоон дотоодын үйлдвэрлэгчдийг зээлийн бодлогоор дэмжих механизмыг хэрэгжүүлэх	2004-2005 2003-2008	-	УХЯ, СЭЗЯ Монгол банк, Арилжааны банкууд, УХЯ БХЯ, СЭЗЯ
3.	Импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих 1/ Улсын зохиалтын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг шагтаруулах уралдаант шагтаруулалт /тендер/-д дотоодын үйлдвэрлэгчдийг хамруулах хурээг өргөжүүлэх 2/ Хувьцаа захиалга, засварын болон үндэсний хувьцаа үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг орон нутагт хөгжүүлэхэд санхүү, зээлийн дэмжлэг үзүүлэх 3/ Шошго, гэмдэг, сав, баглаа боодлын жижиг үйлдвэр байгуулах бизнес эрхлэгчдийн санаачилгыг дэмжих 4/ Импортын материалын бөөний худалдааны нэгдсэн сүлжээ байгуулан ажиллуулах	2004-2008 2003-2008 2003-2004	-	УХЯ, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан УХЯ, Арилжааны банкууд УХЯ, МӨБҮХ

<p>4. Салбарын менежментийг сайжруулж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэн, бүтээмжийн өсөлтийг хангах</p>	<p>1/ Хувиас судлалын төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, мэргэжлийн боловсон хүчний үр чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, сургалт явуулах, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх</p> <p>2/ Хөдөлмөр хамгаалагч, техникийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн шаардлагын стандартыг үйлдвэрлэлийн бүхий л шат дамжлагад мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хатуу хяналт тавих, стандартыг шинэчлэн сайжруулах арга хэмжээ авах</p> <p>3/ Үйлдвэрлэл дундын загвар зохион бүтээх төвийг ажиллуулах</p> <p>4/ ISO-9000 стандартыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, бүтээгдэхүүний чанарын стандартыг олон улсын стандартад нийцүүлэн үндэсний болгон мөрдүүлэх ажлыг зохион байгуулах</p> <p>5/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 20 дугаар зарлигийг хэрэгжүүлэх хүрээнд үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийн өсөлтийг хангах, чанарыг сайжруулах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлэх</p>	<p>2003-2008</p> <p>2003-2005</p> <p>2004-2008</p> <p>2004-2008</p> <p>2003-2008</p>	<p>-</p> <p>1.5</p> <p>-</p> <p>2.0</p> <p>-</p> <p>-</p>	<p>УХЯ, БШУЯ, НХХЯ, МӨБҮХ</p> <p>УХЯ, НХХЯ</p> <p>БШУЯ, МӨБҮХ</p> <p>УХЯ, СХЗТ</p> <p>УХЯ, БШУЯ, НХХЯ, УБХТ, МӨБҮХ, МҮЭНХ</p> <p>НХХЯ, УХЯ, МӨБҮХ, МҮЭНХ</p>
ДҮН		39.0		



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

"Шингэрүүлсэн шатдаг хий" хетелбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хот, суурин газрын дулааны жижиг уурын зуух, айл өрх болон нийтийн тээврийн зориулалт бүхий автомашинуудыг шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээнд шилжүүлэх ажлыг 2003-2005 онд үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Байгаль орчны сайд У.Барсболд, Нийслэлийн Засаг дарга М.Энхболд, Дархан-Уул аймгийн Засаг дарга Д.Хаянхярваа, Орхон аймгийн Засаг дарга К.Даулетбай нарт үүрэг болгосугай.

2. Хийн хангамж, тээвэрлэлт, хадгалалт, үйлчилгээ, хэрэглээний бүх хүрээнд аюулгүй байдлыг хангахтай холбогдсон стандарт, дүрэм, журмыг боловсруулж батлуулах, тэдгээрийг мөрдөж байгаа байдалд хяналт тавьж ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Улсын мэргэжлийн хяналтын газар (Д.БАТБААТАР)-т үүрэг болгосугай.

3. Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгах нь:

а/шингэрүүлсэн шатдаг хийг энэ тогтоолд заасан зориулалтаар ашиглах, энэ чиглэлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд удаан

Шингэрүүлсэн шатдаг хийг хэрэглээнд нэвтрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

хугацаагаар шатдаг хий нийлүүлэх гэрээ байгуулан ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авсугай;

б/шингэрүүлсэн шатдаг хийн хангамж, хэрэглээтэй холбоотой үйл ажиллагаа нь хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой нөлөөлөх аваар, осол гаргах өндөр магадлалтайг харгалзан аюулгүй байдлыг хангасан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл ашиглах болон аюулгүй ажиллагааны онцгой шаардлагуудыг хангахуйц санхүүгийн чадвартай аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой нөхцөлтэйгээр сонгон шалгаруулалт явуулсны үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгож байх арга хэмжээ авсугай.

4. "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 140 дүгээр тогтоолын хавсралтын "Е.40" гэсний "4010" гэсэн заалтын дараа "4020.Шатах хий үйлдвэрлэл, хуваарилалт (шингэрүүлсэн шатдаг хийн хангамж, үйлчилгээ, хэрэглээ)" гэж нэмсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Дэд бүтцийн сайд

Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 22.5, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 16.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Стандартчилал, хэмжил зүйн төвийн дүрэм"-ийг 1 дүгээр хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "...Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйл, ..." гэснийг "Стандартчилал, тохирлын

Дүрэм, бүрэлдэхүүн батлах тухай

үнэлгээний тухай хуулийн 20.3" гэж өөрчлөн найруулж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтыг 2 дугаар хавсралт ёсоор өөрчилсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1995 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 47 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Үйлдвэр, худалдааны сайд

Ч.ГАНЗОРИГ

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг зүйл

1. Стандартчилал, хэмжил зүйн төвийн үндсэн зорилт нь стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагааг төв болон орон нутагт хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, Монгол Улсын стратеги хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн үйлдвэрлэл, худалдааг дахь аливаа техникийн саадыг багасгах, улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхлыг хангах үйл ажиллагааг стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн бодлогоор дэмжихэд оршино.

2. Стандартчилал, хэмжил зүйн төв нь стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, энэ чиглэлээр Монгол Улсын төрөөс баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, түүнийг хэрэгжүүлэх зорилго бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

3. Стандартчилал, хэмжил зүйн төв нь үйл ажиллагаандаа Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн акт, энэ дүрмийг удирдлага болгоно.

Хоёр. Стандартчилал, хэмжил зүйн төвийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц

4. Стандартчилал, хэмжил зүйн төвийн удирдлага нь дарга, дэд даргаас бүрдэнэ.

5. Стандартчилал, хэмжил зүйн төвийн даргыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-д заасны дагуу стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө.

6. Стандартчилал, хэмжил зүйн төвийн дэд даргыг Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг харгалзан стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

7. Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга нь стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийг стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангахтай холбогдсон мэдээллээр хангана.

Гурав. Стандартчилал, хэмжил зүйн төвийн үйл ажиллагаа

8. Стандартчилал, хэмжил зүйн төв нь Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай болон Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхээс гадна дараахь үйл ажиллагаа явуулна. Үүнд:

1) хэмжих хэрэгсэлд загварын туршилт хийх, улсын бүртгэлд бүртгэх, тэдгээрийг хэрэглээнээс хасах талаар холбогдох шийдвэр гаргаж, нийтэд мэдээлэх;

2) хэмжүүрийн улсын шалгагч, баталгаажуулалтын шинжээч, итгэмжлэлийн шинжээч, аудиторыг сургах, аттестатчилах;

3) эрхэлсэн асуудлаараа олон улс, бүс нутгийн болон гадаад орнуудын мэргэжлийн байгууллагуудтай харилцаж, холбогдох журмын дагуу гэрээ, хэлэлцээр байгуулах, мэдээлэл солилцох;

4) холбогдох байгууллагын сорилтын болон хэмжлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, материаллаг баазыг харилцан тохиролцсоны үндсэн дээр ашиглах, мөн гадаад орны холбогдох лабораторид сорилт, харьцуулалт, шалгалт хийлгэх;

5) Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.8-д заасны дагуу хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгох шинжээчийн ажлын хэсгийг томилж дүгнэлт гаргах, холбогдох гэрээ байгуулах;

6) аж ахуйн нэгж, байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын тэмдэг олгох;

7) тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүний жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн дагуу холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

8) тохирлын баталгаанд заавал хамрагдах жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, гадаад улсын тусламжаар оруулж ирэхтэй холбогдсон тендрийн шалгаруулалтад тохирлын баталгааны асуудлаар оролцох;

9) тохирлын баталгааг хүлээн зөвшөөрөх талаар экспортлогч орны холбогдох баталгаажуулалтын байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу тохиролцсон итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын нэр, түүнээс олгох тохирлын гэрчилгээний болон сорилтын дүнгийн хуудасны загвар, тэдгээр нь ямар нэр төрлийн бүтээгдэхүүнд хамаарах тухай мэдээллийг нийтэд мэдээлэх;

10) хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

Дөрөв. Бусад зүйл

9. Стандартчилал, хэмжил зүйн төв нь аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төвийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн

удирдлагаар хангана.

10. Аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн төвийн дүрмийг тухайн шатны Засаг дарга Стандартчилал, хэмжил зүйн төвтэй зөвшилцсөний үндсэн дээр баталж болно.

11. Стандартчилал, хэмжил зүйн төв нь зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

12. Стандартчилал, хэмжил зүйн төв нь өөрийн билэгдэлтэй байж болно.

13. Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн дотоод ажлын хүрээний асуудлаар тушаал гаргана.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 2 дугаар хэсэрлэлт

Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн

Дарга	- Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга	байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга;
Орлогч дарга	- мөн төвийн дэд дарга	- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бага, дунд боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга;
Гишүүд	- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;	- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн газрын дарга;
	- Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,	- Улсын мэргэжлийн хяналтын газрын дэд дарга;
	- Үйлдвэр, худалдааны яамны Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын дарга;	- Зэвсэгт хүчний Цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах албаны орлогч дарга;
	- Санхүү, эдийн засгийн яамны Санхүүгийн зах зээл, салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын газрын дарга;	- Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч;
	- Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн төлөвлөлт, бодлогын газрын дарга;	- Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн гүйцэтгэх захирал /тохиролцооноор/.
	- Эрүүл, мэндийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга;	- Стандартчилал, хэмжил зүйн төвийн ажилтан /орон тооны/.
	- Дэд бүтцийн яамны Барилга, хот	
		Нарийн бичгийн дарга

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 1.5